

МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Н.ДАНГААСҮРЭН
Ц.БААТАР*

Монгол улс, БНСУ-ын хооронд 1990 оны гуравдугаар сарын 26-нд дипломат харилцаа тогтоосноос хойших өнгөрсөн арван нэгэн жилийн хугацаанд хоёр улсын харилцаа улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, шинжлэх ухааны болон дипломатын бүхий л салбарт эрчимтэй хөгжиж ирлээ. Энэхүү бэсрэг өгүүлэлд тэр бүхнийг багтаах боломжгүй тул бид зөвхөн хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг цухас хөндлөө.

Дэлхий хотлоороо улам бүр ойртон, нягтарч, харилцан хамаарал нь гүнзгийрч буй өнөөгийн глобалчлалын эринд хоёр улс улам бүр бие биенээ нөхсөн, харилцан ашигтай хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх, хүсэл эрмэлзэлтэйгээр шинэ зууны босгыг алхлаа. Монгол Улс, БНСУ-ын худалдаа, эдийн засгийн салбарын харилцаа, зах зээлээ тандан судлах, танин мэдэх хүрээнээс хэдийнээ хальж, БНСУ Монголд томоохон хөрөнгө оруулагч түнш улс болж, Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд тус улсын эзлэх байр суурь өнгөрсөн богино хугацаанд огцом өслөө. Анх харилцаа тогтоож байсан 1990 оны үед 2,7 сая ам.доллараас хэтрэхгүй байсан хоёр улсын худалдааны эргэлтийн нийт хэмжээ 1999 он гэхэд 17 дахин өсч 44 сая гаруй ам.долларт хүрчээ. Одоо БНСУ монголын гадаад худалдааны тав дахь түнш болж, монгол орны эдийн засгийн хөгжилд чухал байр суурь эзэлж байна. Хамтарсан болон Солонгосын талын 100 хувийн хөрөнгө оруулалттай 200 гаруй аж ахуйн нэгж төрөл бүрийн салбар чиглэлээр манай оронд 40 сая орчим ам.долларын хөрөнгө оруулаад байна. Самсунг, Хендэ, SK телеком, кореа телеком, Ханжин, Кохан зэрэг Солонгост дээгүүр ордог томоохон групп, нэгдлүүд Монголд хөрөнгө оруулж эхэллээ. Түүнчлэн эдгээр групп нэгдлүүд Солонгосоос Монголд үзүүлэх зээл тусламжинд ч оролцож байна.

Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээ далайцын хувьд хэдийгээр хоёр талын санасан түвшинд хүрээгүй ч гэсэн улс ардын аж ахуйн бараг бүх салбарт хамтын ажиллагааны эхлэл амжилттай тавигдлаа. Солонгосын бизнесменүүд эхний үед гол төлөв үйлчилгээний салбарт түлхүү хөрөнгө оруулж байсан бол сүүлийн үед уул уурхай, геологи хайгуул, ашигт малтмалын чиглэлд ч хөрөнгө оруулах сонирхол өсч

* Н.Дангаасүрэн - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор

* Ц.Баатар - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, (Ph.D)

байгаа нь ажиглагдах болов. Тухайлбал, 1999 онд Солонгосын Уул уурхайн газар, Монгол улсын хооронд ашигт малтмал олборлох салбарт “техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулж, мөн онд Солонгосын Олон улсын хамтын ажиллагааны газар /КОЙКА/-ын ашигт малтмал хайгуулын судалгааны ажилтан нар Монголд айлчлав. Мөн онд Монгол Улсын Ерөнхий сайдын Солонгост хийсэн айлчлалын үеэр Монгол-Солонгос улсын эрчим хүч байгалийн нөөцийн салбарт хамтын ажиллагааны хэлэлцээр байгууллаа. Мөн оны сүүлчээр Улаанбаатар хотноо Монгол, Солонгос улсын Эрчим хүч, байгалийн нөөцийн хорооны чуулга уулзалт боллоо. Энэ бүхэн нь Солонгосын бизнесменүүд дээрх салбарыг ихээхэн анхааран сонирхож байгаагийн зөвхөн нэг жишээ юм. Гэвч өнөө хэр энэ чиглэлд дорвитой хөрөнгө оруулалт байхгүй байна. Эрсдэл ихтэй, хайгуул, судалгаа ултай хийж байж шийдэх цаг хугацаа шаардсан бизнес гэдэг нь ч ойлгомжтой. Тэдэнд Оросын бизнесменүүд шиг монголын уул уурхайн салбарыг судалсан туршлага ч дутагдаж буй бизээ. Нөгөө талаар энэ чиглэлээр хамтран ажиллах хууль эрх зүйн үндэс нэг мөр болж бүрдээгүй тал ч нөлөөлж байна. Хөдөө аж ахуйн салбарт өнөөгийн байдлаар солонгос иргэд монголд ирж хүлэмжинд хүнсний ногоо, улаан буудай, төмс тариалах зэрэг туршилт хийж байна. Тэдний туршилтын үр дүн болсон монголд ургуулсан солонгос техниологоор хийсэн солонгосчуудын өргөн хэрэглэдэг “КИМЧИ” хэмээх байцаан зууш манай хүнсний зах, дэлгүүрүүдээр харагдаж эхэллээ. Энэ нь цаашид энэ чиглэлээр хөрөнгө оруулах боломж байгааг харуулж байна. Монголын үржил шимтэй хөрсөнд солонгосын өндөр технологийг ашиглаж хамтарсан ногооны аж ахуй байгуулбал ажлын байр бий болгох, сайн чанарын хүнсний ногоо хэрэглэх, боломж монгол оронд байна гэж солонгос түншүүд үзэж байна.

Монголын хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхолтой солонгосчууд их байгаа ч манайд энэ талын хууль эрх зүйн орчин бүрдээгүй учир тэд болгоомжилж байна. Энэ нь газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалт хөрөнгө оруулагчдад төдий л таатай биш байгааг харуулж байна.

Дээр бидний өгүүлсэн салбарууд бол хоёр улсын ерөнхийлөгч нарын 1999, 2001 онуудад харилцан айлчлалын үеэр тогтож хэлэлцсэн хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүд юм. Монгол, Солонгосын төрийн тэргүүн нарын уулзалтын үеэр хоёр улсын ерөнхийлөгчид монголын байгалийн нөөцийг Солонгос улсын техник технологи хөгжлийн туршлагыг хамтатган харилцан бие биеэ нөхсөн харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхээр тохиролцсон билээ. Түүнчлэн шинэ зуунд хоёр орны харилцааг “Хөгжлийн түншлэлийн” хэмжээнд хөгжүүлж түншлэлийг манай орны тэргүүлэх салбар болох дээрх хоёр гол салбараас гадна мэдээллийн технологийн салбарт түлхүү хөгжүүлэх нь илүү үр өгөөжтэй байх нь эргэлзээгүй.

БНСУ-ын Засгийн газраас шилжилтийн энэ хүнд үед манай оронд үзүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны сангийн /EDCF/-ийн зээл, тусламж үр шимээ өгч төрийн болон орон нутгийн холбооны сүлжээг шинэчлэх зэрэг хөтөлбөр болон Солонгосын засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 3,1 сая ам.долларын өртөг бүхий долоон төсөл амжилттай хэрэгжиж байна. Ер нь өнгөрсөн хугацаанд буюу 1991-1999 онд нийтдээ 6,5 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлсэн бөгөөд нэг удаагийн тариурын үйлдвэр байгуулахад болон Даланзадгад хотын ДЦС барих хоёр төслийн ажилд 13,2 сая ам.долларын хөнгөлттэй зээл олгоод байна. Солонгосын Засгийн газар 2000-2002 онд 3,1 сая ам.долларын буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэсэн билээ. БНСУ цаашдаа холбооны салбарт зориулж нийтдээ 20,6 сая ам.долларын зээл олгох төслийн асуудал ч яригдаж байна.

БНСУ-ын эдийн засаг өнгөрсөн 3 жилд төдий л таатай биш, Азийн эдийн засгийн хямралд ширвэгдсэн боловч Монголд оруулах хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцаагаа огтхон ч бууруулсангүй. Солонгосын хувьд хоёр зууны зааг жилүүдэд эдийн засгийн хөгжлийн явцад хуримтлагдсан сул тал, улс төр нийгмийн хүрээнд үүссэн сөрөг үзэгдлийг засч залруулах эрс шинэтгэлийн үе байв. Солонгосчууд энэ шинэтгэлээ богино хугацаанд амжилттай хийж хамгийн хүнд хэцүү үеэ одоо нэгэнт ардаа хийж чадлаа. Санхүү эдийн засгийн хямралын хамгийн эгзэгтэй хүнд үе улс оронд нь нүүрлэхэд ард иргэд нь амин хувийнхаа алтан эдлэлийг хүртэл сайн дураар цуглуулж, бэрхшээлээс гарах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлсэн нь хүнд нөхцөлд солонгосын ард түмэн зангидсан гар шиг нягтарч чаддаг үндэсний эх оронч сэтгэлгээ, халуун эв нэгдэл, улс төрийн өндөр ухамсартай болохоо дахин илтгэн харууллаа. Энэ байдал ч гэсэн бидний монголчуудад үндэсний идэвхжил, эв нэгдэл гэдэг ямар их хүчтэй, юуг ч даван туулж болохын нэгэн сайхан үлгэр дууриалал суралцах ёстой эрхэм зүйлийн нэг юм.

БНСУ-ын хөгжлийн туршлагаас суралцах, технологи, ноу-хаут Монгол улсад дамжуулах үүднээс солонгосчууд “Эрдэм мэдлэгийн түншлэл” хөтөлбөр боловсруулжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд оюун ухааны болон хүний нөөцийн хамтын ажиллагааны нэг хэсэг болгон Монгол улсын зах зээлийн эдийн засаг, ардчилал шинэчилэлийг бүх талаар дэмжин хоёр улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хот дүүрэг, мужуудын хооронд шууд харилцаа тогтож нийтдээ хоёр талд 100 гаруй оюутан, аспирант, доктурлант суралцаж байна.

Монгол солонгосын харилцаа эдүгээ хувь хүн, айл өрх, ижил мэргэжил сонирхолтой хүмүүс, орон нутгийн болон олон нийт, хүмүүнлэгийн байгууллагуудын хэлхээ холбоо нийтлэг харилцааны гол бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Өнөөгийн байдлаар хоёр орны худалдааны эргэлтийн ихэнхи хэсгийг хувийн хэвшлийнхэн гүйцэтгэж байгаа бөгөөд монголчуудад солонгосын хүнсний бараа богино хугацаанд танил дасал болсоор байна. Хойд хөршийн суудлын тэрэг одоо солонгосын суудлын тэргэнд байр сууриа тавьж өгөөд байна. Монголын автомашины паркыг үндсэндээ солонгосын машин бүрдүүлэх боллоо.

Солонгосын өргөн хэрэглээний бараа манай охид хөвгүүдийн өдөр тутмын хэрэглээ болж урд хөршийн чанаргүй барааг зах зээлээс аажмаар түрж эхэллээ. Хоёр орны хооронд иргэд харилцан зорчих, жуулчлах явдал жилээс жилд өсөн нэмэгдэж өнөөгийн байдлаар жилд дунджаар 10 мянга гаруй хүн харилцан зорчиж байна.

БНСУ-ын хууль зүйн яамны мэдээгээр Солонгост манай 11 мянга орчим иргэн хууль бусаар оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа юм билээ. Эдгээр хүмүүс эргээд эх орондоо жилд дунджаар хамгийн багаар тооцооход 20-30 сая ам.долларын орлого оруулж байна. Хууль бусаар оршин суудаг болохоор тэдэнд нийгмийн хамгааллын холбогдолтой бэрхшээлээс гадна маш хүнд хортой нөхцөлд уртасгасан цагаар асар их тэвчээр хөлс хүчээ дайчлан зовж зүдэрч энэ мөнгийг олж байна. Хэдийгээр ийм асар их хүндрэл бэрхшээлийн дунд амь өрсөн хөдөлмөрлөж байгаа ч зах зээлийн орчинд ажиллаж амьдрах арга ухаанд суралцаж, хөлс гоожуулсан хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэрч, хэрэгтэй зүйл эх орондоо нэвтрүүлэх, хөдөлмөрийнхөө үр шимээр улс орноо өөд нь татах сэтгэл зүй төлөвшин бүрэлдэж байна гэж судлаачид үзэж байна. Энэ бол үнэхээр мөнгөн илэрхийллээр хэмжиж үл болох үнэт хуримтлал юм.

Монгол, Солонгосын хооронд хууль ёсны ажилчдын тоог нэмэгдүүлэх асуудал ч сүүлийн үед нэлээд ахицтай байна. 1995-1996 онд манай улсын холбогдох газрууд гэрээт ажилчдаа БНСУ-д оруулах асуудал тавьж нааштай шийдвэр гаргуулж байв. Энэ нааштай ажлын эхлэл асуудал хариуцсан хүмүүсийн хариуцлагагүй, ургацгүй үйл ажиллагаанаас болж мухардмал байдалд орсныг БНСУ-д суугаа Монголын элчин сайдын яамны ажилтнууд сэргээн хөөцөлдөж 1998 оноос 500 ажилчин элсүүлэн авч ажиллуулах гэрээ шинэчлэн байгуулж холбогдох байгууллагуудтай нь тохиролцсон аж. 2000 оны эхээр Монголоос сонгон шалгаруулсан хүмүүс гэрээний дагуу ажиллах газраа ажиллаж эхэлжээ. Иймэрхүү албан ёсны гэрээ хэлэлцээрийг цаашид үргэлжлүүлж хууль ёсны хөдөлмөр эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх асуудал чухал юм. Энэ нь хөдөлмөр хамгаалал, ажлын нөхцөл, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд Солонгос ажилчдын нэгэн адил хамрагдах, эдлэх хөнгөлт, хангамж зэргээр зүй ёсоор авах эрхээр баталгаажина гэсэн үг.

Энэ оны хоёрдугаар сард Монгол улсын Ерөнхийлөгч БНСУ-д айлчлах үеэр “Хууль бусаар” хөдөлмөр эрхэлж буй манай иргэдийг

хүнийх нь хувьд анхаарч хөдөлмөрлөх нөхцөлийг нь сайжруулж, солонгос ажилчдын адил нөхцөл бүрдүүлж өгөхийг хүссэнийг солонгосын тал нааштайгаар хүлээж авсан билээ. Энэ нь Солонгосын тал Монгол улс, монголчуудад хэрхэн найрсаг хандаж байдгийн бас нэгэн илрэл боллоо. Гагцхүү тэнд ажиллаж буй монгол иргэд хүний газар нэрээ, улсаа бодож элдэв хэрэг зөрчилд холбогдохгүй байх явдал юм.

Мөн хоёр улсын төрийн тэргүүн нар БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн туршлага болон мэргэжлийн ур чадварыг монголчуудад эзэмшүүлэхийн тулд Knowledge Partnership хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тохиролцож энэ онд төсөв, татвар, мөнгө санхүүгийн салбарын солонгосын мэргэжилтэнг Монгол улсад томилон ажиллуулж Монголын эдийн засгийг хөгжүүлэх бодлого боловсруулах, зөвлөлтөө өгөх зэргээр хамтран ажиллахаар тохиролцсон нь маш чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Зүүн хойд Азийн бүс нутгийн интеграцид хоёр улс хамтран ажиллах, бүс нутагт учирсан элсний нүүдэл, цөлжилт зэрэг байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд бүс нутгийн олон талын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцохоор харилцан тохиролцсон нь монгол улс бүс нутгийн хамтын ажиллагаанд түлхүү оролцох боломжийг нээж байна.

Монгол, Солонгосын эдийн засаг худалдаа харилцааны өнөөгийн байдлыг цухас авч үзэхэд Солонгосын хөрөнгө оруулагчдын хувьд элдэв саад бэрхшээл байгаа нь мэдээж. Гэвч тэр болгон үлгэр жишээ болохуйц үр ашигтай ажиллаж чадахгүй байна. Яваандаа аль аль талдаа зүгширч харилцан ашигтай хамтран ажиллах нь эргэлзээгүй. Одоо нэгэнт хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны суурь батжин бэхжиж улмаар бүс нутгийн хэмжээнд олон талт хамтын ажиллагааны эхлэл тавигдаж байгаа нь бүр ч чухал ач холбогдолтой.

Солонгосын хойгийн байдал харьцангуй тогтворжиж солонгос хоорондын хамтын ажиллагаа сэргэж, төмөр зам, засмал замаа сэргээн босгож байгаа нь Монгол улсад ч хамаарах асуудал юм. Хоёр Солонгосын хамтын ажиллагааны өрнөл нь Монгол БНСУ-ын худалдаа, эдийн засгийн харилцаанд эерэг нөлөө үзүүлнэ гэж ажиглагчид үзэж байна.

БНСУ шинэ зуунд мэдлэг мэдээлэл, оюуны багтаамжтай үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх гараанд шуудран орлоо. Энэ бол тус улсын хөгжлийн ирээдүйн чиг хандлага юм. Солонгост оюуны багтаамжтай үйлдвэрлэлийн нэрийн хуудас болсон аж ахуйн нэгж өдөрт дундаар 30-иар нэмэгдэж, 2005 онд 40 мянгал хүрэх аж. Одоо Солонгост дөрвөн хүн тутмын нэг буюу 10 сая хүн интернет ашиглаж байна.

Монгол улс, монголчууд бид ийм улс, ард түмэнтэй улам бүр ойртон нягтарч хамтран ажиллах нь хөгжил дэвшлээ хурдасгах нэгэн хүчин зүйл болох нь дамжиггүй.